



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 583

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 7,828,000.00 (долоон сая найман зуун хорин найман мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геологи, уул уурхайн сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геологи, уул уурхайн сургуулийн захирал Б.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАНБАТ



Б.ГАВАА

0002599

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 4 дугаар сарын 19-ны өдрийн
38.3 дугаар тогтоолын хавсралт

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм- жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Найрлагын бүрэлдэхүүн тодорхойлох багаж	2008.12.31	ш	1	2,640,000	2,640,000	2,640,000	0
2	Кинематик зууралдлага тодорхойлох багаж	2008.12.31	ш	1	2,750,000	2,750,000	2,750,000	0
3	Царцах температур тодорхойлох багаж	2008.12.31	ш	1	550,000	550,000	550,000	0
4	Ноцох температур тодорхойлох багаж	2008.12.31	ш	1	1,540,000	1,540,000	1,540,000	0
5	Ус нэрэх багаж дистиплятор	2008.12.31	ш	1	348000	348000	348000	0
	Нийт дүн					7,828,000.00	7,828,000.00	0
						(долоон сая найман зуун хорин найман мянга)	(долоон сая найман зуун хорин найман мянга)	